



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 1/09

Номгон

Аюулгүйн нөөцийн өвс тэжээлийг
хүлээж авах, хяналт тавих ажлын
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 9/61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум дундын ойн ангиас Баян-Өсөх агро орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хөрөнгө шилжүүлэх, цаашид аймгийн өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Наранбаяр

Засаг даргын орлогч

Гишүүдэд:

Г.Энхбаяр

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Эрхэмбаяр

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Л.Жаргалцэцэг

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга

А.Дорждулам

Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

С.Бандихүү

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Малын Бэлчээрийн менежментийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Б.Биндэръяа

Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

625010021

2.Сум дундын ойн ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 19 нэрийн хөрөнгийг Баян-Өсөх агро орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэх ажилд хяналт тавьж, бүртгэлжүүлэн, аймгийн өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж, аймгийн Засаг дарга, Онцгой комиссыг тухай бүр мэдээллээр хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Наранбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д даалгасугай.

